

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2022/19/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Төлбөрийн акт	13
4.3 Албан шаардлага	13
4.4 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.02.25 № 44

танай _____ -ны № _____ -т

Г Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин 2,504.9 мянган төгрөгийг зарцуулсан, томилолтыг илүү хоногоор бодож, бүрдэл дутуу баримтаар 610.0 мянган төгрөг илүү олгосон, батлагдсан төсвийг 3,474.8 мянган төгрөгөөр хэмнэж ажиллаагүй зэрэг нийт 7,689.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

023030055

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,550,500.00	4,025,562.72
33	АВЛАГА	-	68,437.72
335	Бусад авлага	-	68,437.72
3351	Байгууллагаас авах авлага	-	68,437.72
35	БАРАА МАТЕРИАЛ	2,550,500.00	3,957,125.00
354	Хангамжийн материал	2,550,500.00	3,957,125.00
35410	Бичиг хэргийн материал	432,000.00	271,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,832,500.00	1,570,125.00
35470	Бусад хангамжийн материал	286,000.00	2,115,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,281,330.11	8,897,084.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,281,330.11	8,897,084.59
392	Биет хөрөнгө	2,281,330.11	8,897,084.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,319,430.00	3,670,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(30,319,430.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,690,060.00	2,970,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,690,060.00)	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,559,370.84	7,261,670.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,278,040.73)	(5,004,586.25)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,831,830.11	12,922,647.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	270,372.34	214,043.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	270,372.34	214,043.34
413	Өглөг	270,372.34	214,043.34
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	260,372.34	41,043.34
4136	Бусад өглөг	10,000.00	173,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	10,000.00	10,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	163,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,561,457.77	12,708,603.97
51	Засгийн газрын хувь оролцоо	4,561,457.77	12,708,603.97
512	Хуримтлагдсан үр дүн	4,561,457.77	6,068,603.97
51210	Өмнөх үеийн үр дүн	4,561,457.77	4,561,457.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,507,146.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	6,640,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,831,830.11	12,922,647.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	99,575,286.00	138,230,820.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	702,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	702,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	702,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	702,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,575,286.00	137,528,520.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	96,643,400.00	129,105,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	96,643,400.00	129,105,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,931,886.00	8,422,720.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,322,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,217,600.00	7,100,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	96,199,800.58	136,723,673.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,199,800.58	136,723,673.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,980,900.58	135,890,327.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,933,503.00	89,975,457.00
210101	Үндсэн цалин	49,933,503.00	66,713,248.00
210102	Нэмэгдэл	-	20,121,525.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,140,684.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,244,164.00	11,980,283.64
210201	Тэтгэврийн даатгал	4,246,824.00	8,343,883.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	399,468.00	727,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	99,867.00	181,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	998,669.00	1,818,200.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,862,652.00	5,880,644.00
210301	Гэрэл, цахилгаан	273,978.00	276,188.00
210302	Түлш, халаалт	833,800.00	855,778.00
210303	Цэвэр, бохир ус	157,774.00	265,178.00
210304	Байрны түрээс	2,597,100.00	4,483,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,682,213.00	10,006,581.80
210401	Бичиг хэрэг	409,600.00	1,352,499.80
210402	Тээвэр, шатахуун	4,570,436.00	5,755,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	702,177.00	1,451,532.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,446,950.00
2105	Нормативт зардал	320,400.00	213,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	320,400.00	213,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	178,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	178,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,610,000.00	6,845,500.00
210702	Дотоод албан томилолт	1,610,000.00	6,845,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	9,957,165.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	9,707,165.04
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	327,968.58	853,245.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	126,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	327,968.58	726,545.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,218,900.00	833,346.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,218,900.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,218,900.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	833,346.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	365,846.80
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	-	467,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,375,485.42	1,507,146.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,375,485.42	1,507,146.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	99,575,286.00	137,528,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,575,286.00	137,528,520.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	96,643,400.00	129,105,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	96,643,400.00	129,105,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,931,886.00	8,422,720.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,322,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,217,600.00	7,100,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	94,515,530.00	137,528,520.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	94,515,530.00	137,528,520.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,296,630.00	136,695,173.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,454,800.00	90,604,672.40
210101	Үндсэн цалин	33,646,800.00	67,342,463.40
210102	Нэмэгдэл	10,117,200.00	20,121,525.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,690,800.00	3,140,684.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,888,423.00	12,272,800.00
210201	Тэтгэврийн даатгал	4,069,823.00	8,636,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	454,800.00	909,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	363,600.00	727,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	91,200.00	181,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	909,000.00	1,818,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,862,652.00	5,880,644.00
210301	Гэрэл, цахилгаан	273,978.00	276,188.00
210302	Түлш, халаалт	833,800.00	855,778.00
210303	Цэвэр, бохир ус	157,774.00	265,178.00
210304	Байрны түрээс	2,597,100.00	4,483,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,842,577.00	11,270,056.80
210401	Бичиг хэрэг	409,600.00	1,191,999.80
210402	Тээвэр, шатахуун	3,730,800.00	5,523,365.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	702,177.00	1,421,392.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,133,300.00
2105	Нормативт зардал	320,400.00	356,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	320,400.00	356,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	178,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	178,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,610,000.00	6,845,500.00
210702	Дотоод албан томилолт	1,610,000.00	6,845,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,317,778.00	9,160,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,317,778.00	8,910,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	126,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	126,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,218,900.00	833,346.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,218,900.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,218,900.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	833,346.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	365,846.80
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	-	467,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,059,756.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,059,756.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	32,934,281.08	-	32,934,281.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	32,934,281.08	-	32,934,281.08
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,950,169.98)	-	(7,950,169.98)
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,561,457.77	-	4,561,457.77
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,561,457.77	-	4,561,457.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	4,561,457.77	-	4,561,457.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	6,640,000.00	-	-	6,640,000.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,507,146.20	-	1,507,146.20
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	6,640,000.00	6,068,603.97	-	12,708,603.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	129,105,800.00	128,739,953.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	129,105,800.00	128,739,953.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,105,800.00	128,739,953.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,909,900.00	90,604,672.40
210101	Үндсэн цалин	73,263,300.00	67,342,463.40
210102	Нэмэгдэл	14,265,300.00	20,121,525.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3381300.00	3140684.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,272,800.00	12,272,800.00
210201	Тэтгэврийн даатгал	8,636,400.00	8,636,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	909,100.00	909,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	727,300.00	727,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	181,800.00	181,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,818,200.00	1,818,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,880,700.00	5,880,644.00
210301	Гэрэл, цахилгаан	276,200.00	276,188.00
210302	Түлш, халаалт	855,800.00	855,778.00
210303	Цэвэр, бохир ус	265200.00	265178.00
210304	Байрны түрээс	4483500.00	4483500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,482,900.00	7,422,336.80
210401	Бичиг хэрэг	947,000.00	946,999.80
210402	Тээвэр, шатахуун	3,213,300.00	3,243,365.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,359,300.00	1,268,672.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,963,300.00	1,963,300.00
2105	Нормативт зардал	356,400.00	356,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	356,400.00	356,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	178,200.00	178,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	178,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,738,000.00	2,738,000.00
210702	Дотоод албан томилолт	2,738,000.00	2,738,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,160,200.00	9,160,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	8,910,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,700.00	126,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	126,700.00	126,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	129,105,800.00	128,739,953.20
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	129,105,800.00	128,739,953.20
131001	Улсын төсвөөс санхүүжих	129,105,800.00	128,739,953.20

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,422,720.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,422,720.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,955,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,847,720.00
210401	Бичиг хэрэг	245,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,280,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	152,720.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,170,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,107,500.00
210702	Дотоод албан томилолт	4,107,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	467,500.00
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	467,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,422,720.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,422,720.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,322,720.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,100,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт нь иргэн, аж ахуйн нэгж байгууллага, орон нутаг бүрийн амьдрал, хөгжлийн зорилгоо биелүүлэх бүхий л хэрэгцээнд нь нийцсэн баталгаатай, чанартай, хүрэлцээтэй усаар хангах замаар хөгжлийг тэтгэж байгаль, орчин, эко системийн тэнцвэрт байдлыг тогтвортой хадгална.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон бусад дотоод аудитын байгууллагаас 2021 онд тус байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 169.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Өмнөх оноос тайлант онд нийт зардал буурсан учраас материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.1 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	0.1	(0.1)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	2.6	4.0	(1.4)
Үндсэн хөрөнгө	2.3	8.9	(6.6)
Нийт хөрөнгө	4.8	12.9	(8.1)
Өр төлбөр	0.3	0.0	0.3
Засгийн газрын оролцоо	4.6	12.9	(8.4)
Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/	-	-	-
Өмнөх үеийн үр дүн	4.6	4.6	-
Тайлант үеийн үр дүн	-	1.7	(1.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	6.6	(6.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4.8	12.9	(8.1)

Бараа материалын дансны үлдэгдэл 1.4 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6.6 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны өр 0.3 сая төгрөг бүрэн барагдуулсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12.9 сая төгрөгөөр өссөн нь дээд газраас шилжиж ирсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 29.3 сая төгрөгөөр буюу 17.5 хувиар буурсан нь өмнөх оноос санхүүжилт буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 33.0 сая төгрөгөөр буюу 19.6 хувиар буурсан нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 175.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 129.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг 129.1 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 129.1 сая төгрөгөөр санхүүжиж, урсгал үйл ажиллагаандаа 128.7 сая төгрөгийг зарцуулж, 0.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 1.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7.1 сая төгрөг нийт 8.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 8.0 сая төгрөгийг зарцуулж, 0.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцлох асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий санхүүжилтийн орлого 120.2 сая төгрөгийн 12 гүйлгээ гарсныг бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын тайлан гаргалт, тооллого, тооцоо бодолт, шатахууны зарцуулалтын тооцоог авч үзэх болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7.7 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 1.1 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж ажилласан.

4.1 Залруулсан алдаа

Цалингийн зардлыг тооцоолсон цалингаас 1.1 сая төгрөгөөр илүү бүртгэснийг аудитын хугацаанд залруулав.

4.2 Төлбөрийн акт

Томилолтыг үнэмлэхэд тодорхойлсон хоногоос илүү бодож, баримтын бүрдэл дутуу баримтыг үндэслэн 0.6 сая төгрөг илүү олгосон.

4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 3.4 сая төгрөгөөр хэмнээгүй, тэвчиж болох зардлыг тэвчээгүй.

Гэрээт ажилтны 0.4 төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас төлсөн.

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг 2.1 сая төгрөгөөр зөрчсөн.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргаа	4	4.2	1	1.1	1	0.6	2	2.5		
Дүн		4	4.2	1	1.1	1	0.6	2	2.5		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргаа	1	3.5					1	3.5		
		1	3.5					1	3.5		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 03/АДЗ70448
ХЭА-2022/19/НА - СНА-ТШЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтыг үнэмлэхэд тодорхойлсон хоногоос илүү хоногоор тооцож, бүрдэл дутуу баримтаар 610.0 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4-т "Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь::

1. Бүрдэл дутуу баримтаар, хоногийн тооцоог илүү тооцож олгосон 610.0 мянган төгрөгийн томилолтыг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлдэх
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нандинцэцэг, нягтлан бодогч Д.Эрдэнэтуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 24/2370/448
ХТ-А - 2022/19/НА - СТА - ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийг хэмнэж ажиллах арга хэмжээ аваагүйгээс 3.5 сая төгрөгийн зардлыг хэмнээгүй зөрчил илэрсэн.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн голын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нандинцэцэг, нягтлан бодогч Д.Эрдэнэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Б.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 25/А2370448
ХТ-А-2022/19/НТ-СТ-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин 2.1 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн голын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нандинцэцэг, нягтлан бодогч Д.Эрдэнэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

02304005



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 25

Дугаар 26/А2370448
ХЭА-2022/19/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас 0.4 сая төгрөгийн гэрээт ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг төлж, батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн голын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нандинцэцэг, нягтлан бодогч Д.Эрдэнэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

